



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бууцагаан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/95/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
Бууцагаан сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн үйлчилгээг түргэн шүүрхай, хүртээмжтэй хүргэж иргэн бүрийг үр бүтээлтэй хөдөлмөрлөх, сайн сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлэх явдал мөн” оршино.	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	16
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.027 № 210
танай _____ -ны № _____ -т
Г Аудитын гэрчилгээ 7

Г БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЛХАГВАДОРЖ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020167

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн.

1. Өмнөх оны буюу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

2. 2019 оны жилийн эцсийн тооллогын комисс томилогдсон тооллогын бүртгэлийг хийж, үр дүнг хэлэлцэж баталгаажуулаагүй.

3. Нягтлан бодогч нь нярвын тайланг сар бүр хянаж баталгаажуулдаггүйгээс нярвын тайлан, санхүүгийн тайлангийн бараа материалын орлого, зарлага зөрүүтэй, өр, авлагыг баталгаажуулаагүй байна.

4. Зочид төлөөлөгч хүлээн авах зардалд батлагдсан 9,1 сая төгрөгийг зарцуулахдаа зохих журмын дагуу тушаал шийдвэрийг гаргахгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталж мөрдөж ажиллах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллыг ашиглах зааврын 6 дугаар хавсралтын "Зочид төлөөлөгч хүлээн авах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.


Дээрх алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулгын Үнэн зөв байх, Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.1. Оршил

Бууцагаан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Бууцагаан сумын ЗДТГ-ын Д.Лхагвадорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Бууцагаан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дах Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бууцагаан сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж иргэн бүрийг үр бүтээлтэй хөдөлмөрлөх, сайн сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлэх явдал мөн” оршино.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Бууцагаан сумын ЗДТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бууцагаан сумын ЗДТГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Aculous” программ хангамж ашигладаг байна..

Бууцагаан сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Бууцагаан сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 596572,6 мянган төгрөгөөс тооцон 11931,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 852368,9 мянган төгрөгөөр тооцсон нь 17047,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бууцагаан сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 145492,9 мянган төгрөгөөр буюу 4,2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	28,928.9	1,201.8	(27,727.1)
Бараа материал	73,649.5	128,375.2	54,725.7
Үндсэн хөрөнгө	5,083,693.0	5,321,996.6	238,303.6
Хуримтлагдсан элэгдэл	(1,761,034.3)	(2,171,829.3)	(410,795.1)
Нийт хөрөнгө	3,425,237.1	3,279,744.2	(145,492.9)
Өр төлбөр	20,336.4	2,177.6	(18,158.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,404,900.7	3,277,566.6	(127,334.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,425,237.1	3,279,744.2	(145,492.9)

Авлага дансны үлдэгдэл 27727,1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд авлагыг хөрөнгө худалдан авч хааснаас авлага буурч шинээр 1201,8 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалжээ. Тайлант онд шинээр үүссэн авлага нь гэрэл цахилгааны авлага 514,0 мянга, тээвэр шатахууны авлага 637,0 мянга бусад зардлын тооцооны авлага 50,8 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54725,7 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 1568,8 мянга түлш шатах тослох материал 3080,4 мянга, бусад хангамжийн материал 65936,8 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ. Бусад хангамжийн материал 65936,8 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн 63784,3 мянган төгрөгийн хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 238303,6 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн хөрөнгөөр 4570,0 мянга, хандив тусламжаар 107020,4 мянга, шилжүүлэн авсан 162602,8 мянга, урд оны авлагаас 27064,6 мянган төгрөгийн хөрөнгө орлого авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 18158,8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны эхэнд 20336,4 мянган төгрөгийн өртэй байсан ба тайлант хугацаанд өглөгийг барагдуулж шинээр 1088,1 мянган төгрөгийн өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3277566,6 мянган төгрөг болж 127334,1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 127334,1 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 31763,1 мянган төгрөгийн бичилт нь барилга байгууламж худалдсантай холбоотой хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс буурсантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Бууцагаан сумын ЗДТГ нь тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоос 600,0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 2429,9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 405 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өөрийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	600,0	2429,9	1829,9	405
Нийт дүн	6000,0	2429,9	1829,9	405

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх ЗДТГ-ын хөтөлбөрт зориулан 350606,5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 350606,5 мянган төгрөгийг урсгал зардалд, зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 344947,3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10600,0 мянган төгрөгийг урд оны үлдэгдлээс, 600,0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 345527,3 мянган төгрөг буюу 99,1 хувьтай байгаа ба хэмнэгдсэн 5164,3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь бараа үйлчилгээний зардлаас 2304,0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1000,0 мянга, бусдаар гүйцэтгүүлсний төлбөр хураамжаас 1106,4 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд тухайн тайлант хугацаанд 42794,1 мянган төгрөг орлого орж, зарцуулсан байна. Үүнд өвсний үнэ 384,0 мянган төгрөг, 2018 оны үлдэгдлээс 24078,9 мянган төгрөг, Хаш-Ойл ХХК-аас шатахууны борлуулалтын урамшуулал 1132,2 мянган төгрөг, Хог тээврийн орлогоос 10753,9 мянган төгрөг, ГБХХГ-аас 1500,0 мянган төгрөгийн хамтарсан багийн санхүүжилт төслийн орлого, аймгийн Засаг даргын А/410 дугаар захирамжаар 2000,0 мянган төгрөгийн ойн арга хэмжээнд зориулж, хуучин эмнэлгийн барилгын түрээсийн орлого 1200,0 мянган төгрөг тус тус орсон байна. Дээрх орлогоос хог тээвэр ажилчдын цалин, НДШ, шатахууны зардалд 9779,1 мянган төгрөг, хуучин дотуур байрны засварын зардалд 19291,1 мянган төгрөг, өвсний үнэнд 519,0 мянган төгрөг, хүүхдийн баярын бэлгэд 337,5 мянган төгрөг, урд оны ерөнд 405,6 мянган төгрөг, сумын ахмадын хүндэтгэлийн зардалд 1000,0 мянган төгрөг, ХГБХГ-т хамтарсан багийн санхүүжилт 1500,0, угаалгын машин 290,0 мянган төгрөг, хоолны мөнгө 288,7 мянган төгрөг, ЗДТГ-ын 2019 оны тайлан сэтгүүлийн үнэнд 3550,0 мянган төгрөг, ЗДТГ-ын машины дугуй 1982,1 мянган төгрөгийг тус тус зарцуулж 105,0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 37 эрсдэл тодорхойлж нийт 37 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 172336,3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5350,8 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 62461,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж, 104524,5 мянган төгрөгийн 3 албан шаардлага өглөө.

**Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)**

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	7	62461,0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	5350,8	
3	Албан шаардлага өгсөн	3	104524,5	
	Дүн	9	172336,3	

Аудитаар дараах 76795,3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 7380,5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тус сумын Засаг даргын 2019 оны 10 сарын 7-ны өдрийн А/90 дугаар захирамж, ЗДТГ-ын даргын 2019 оны 10 сарын 1-ний өдрийн А/18 дугаар тушаалыг үндэслэн цалингийн сангаас 5350,8 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлтийг ажилтнуудад олгосон байна.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Сангийн сайдын 2014 оны “Эдийн засгийн ангилал” батлах тухай 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын “Цалин хөлс ба нэмэгдэл урамшил” гэсэн эдийн засгийн ангилал, заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох

2 Тус байгууллага нь дулаан ханган нийлүүлэгч “РМБ” ХХК-тай сард 3412,2 мянган төгрөг төлөх гэрээг байгуулж, 12 сард 2029,7 мянган төгрөгийг илүү шилжүүлж, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”,6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” зэрэг заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Санхүүгийн тайлан баланст бүртгэлтэй тракторыг хувь хүнд түрээслүүлж ашиглуулж байгаа ба улсын бүртгэлийн гэрчилгээ нь олдохгүй, галын машин 2014 онд авсан боловч одоо болтол байгууллагын эзэмшилд шилжүүлээгүй, мал үржлийн тасгийн мотоциклийг алдсан гэсэн тайлбарыг нягтлан бодогч өглөө.

Энэ нь Авто тээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17^{1.1} дэх “Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 3.5.5-д “ Захиалагч худалдан авсан тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа энэ журмын дол дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу акт, үйлдэж тамга тэмдэг дарж баталгаажуулна.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага өгөх

4. Өмнөх оны буюу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 2019 оны жилийн эцсийн тооллогын комисс нь тооллогын бүртгэлийг хийж, үр дүнг хэлэлцэж баталгаажуулаагүй,нягтлан бодогч нь нярвын тайланг сар бүр хянаж баталгаажуулдаггүйгээс нярвын тайлан, санхүүгийн тайлангийн бараа материалын орлого, зарлага зөрүүтэй, өр, авлагыг баталгаажуулаагүй,зочид төлөөлөгч хүлээн авах зардалд батлагдсан 9,1 сая төгрөгийг зарцуулахдаа зохих журмын дагуу тушаал шийдвэрийг гаргахгүйгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн аудитаар илэрсэн алдааны дүн урьдчилан тогтоосон материаллаг байдлын дүнгээс давсан тул сөрөг дүгнэлт өгч, төрийн аудитын тухай хуулийн 28.1-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг сумын Засаг дарга Ж.Алтанцэцэгт хэргүүлэв

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага өгөх

2.13. Шилэн дансны мэдээлэл

Бууцагаан сумын ЗДТГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 105 мэдээллийг хугацаанд нь, 44 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй /Хугацаа болоогүй/
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	30	6	
5	Тухай бүр	8	96	61	35	
6	Нийт	27	151	105	44	2

Бүтэн жилээр байршуулах 11 мэдээллээс 7 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Хугацаа хоцроосон дараах мэдээллүүд байна.

- Байгууллагын батлагдсан төсөв
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

Хугацаа болоогүй мэдээллүүд нь:

- Санхүүгийн тайлан
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт

Хагас жилээр байршуулах 4 мэдээллийг хугацаанд байршуулсан байна. Сар бүр байршуулах 36 мэдээллээс 30 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /1 сар, 9 сар/
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл /1 сар, 9 сар
- Байгууллагын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлт / 1 сар, 9 сар

Тухай бүр байршуулах 96 мэдээллээс 61 мэдээллийг хугацаанд нь 35 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд

- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт /1сар,9 сар/
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ /1-9 сар хүртэл/
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /1 сар, 5 сар,9 сар/
- Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг /1-9 сар хүртэл/

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 67.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, 63135.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай байгууллагын даргын 2019 оны 05 сарын 20 өдрийн 2/91 дугаар албан бичгээр ирүүлсэн ч тухайн тайланд онд 2018 онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдааг давтан гаргасан байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бууцагаан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн

Сөрөг санал дүгнэлт

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна..

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын бусад хангамжийн материалд үлдэгдлээр байгаа 5,0 сая төгрөгийн өвсний тооцоо, тооллогыг хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө тохиолдолд заавал хийнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Хөрөнгө дутагдах

1.3. Өгсөн зөвлөмж:

Өвсний тооллогыг комисс томилон хийж үр дүнг хэлэлцэн, төлбөр тооцоог хийж дуусган албан тоотой 2020 оны 4 дүгээр сарын 15-ны дотор хариу ирүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт:

Тухайн тайлант хугацаанд Засаг даргын нөөц хөрөнгө 17000,0 мянган төгрөг батлагдаж 10798,0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нөөц хөрөнгө зарцуулахдаа Сангийн сайдын 2018 оны 12 сарын 31-ны өдрийн 318 дүгээр тушаалыг баримтлалгүй сумын Засаг даргын захирамж гаргахдаа хүчингүй болсон Сангийн сайдын 2012 оны 11 сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалыг баримталж 12224,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2018 оны 12 сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна

2.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2018 оны 12 сарын 31-ны өдрийн 318 тушаалыг үндэслэн тухай бүр нь тушаал шийдвэр гарган зарцуулж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж гүйцэтгэлд нь хяналт тавьж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

3. Зардлын данстай холбоотой

3.1. Илрүүлэлт:

Зочид төлөөлөгч хүлээн авах зардлыг анх 4,0 сая төгрөг батлагдаж, тодотголоор нэмж 5,0 сая төгрөгийн зохицуулалт хийж, гүйцэтгэлээр 9,1 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтаас түүвэрлэн шалгахад хүнсний материал, хоолны зардалд зарцуулахдаа шийдвэргүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллыг ашиглах зааврын 6 дугаар хавсралтын “Зочид төлөөлөгч хүлээн авах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх

3.3. Өгсөн зөвлөмж:

Зочид төлөөлөгч хүлээн авах зардлыг Сангийн сайдын 55-р тушаалын “Зочид төлөөлөгч хүлээн авах” гэсэн ангилалд заасан “Гадны зочид төлөөлөгч, тухайлбал Монгол улсад гадаад улсаас ирэх албан төлөөлөгч, гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад Монгол улсын болон бусад орны албан төлөөлөгч айлчлахтай холбоотойгоор гарах зочид буудал, хоол, унаа, бэлэг дурсгалын эд зүйлс олгох зардлыг энэ ангилалд тусгана” гэсэн заалтыг мөрдөж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

4. Балансын данстай холбоотой

4.1. Илрүүлэлт:

Тайлант оны 1201,8 мянган төгрөгийн 1833,6 мянган төгрөгийн өглөгтэй гарсан ба үлдэгдлийг баталгаажуулсан тооцоо нийлсэн акт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4 Үнэн зөв байх гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.2 Эрсдэл

Санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өр төлбөр буруу тусгагдсан байх

4.3 Өгсөн зөвлөмж

Санхүүгийн тайланд тусгагдсан өглөг, авлагын тооцоо нийлсэн актаар баталгаажуулж Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Хүлээн зөвшөөрсөн

5. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

5.1 Илрүүлэлт

Тайлант хугацаанд 22663,1 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардал батлагдаж гүйцэтгэлээр зарцуулсан байна. Үүнийг нярвын тайлан, жолоочийн тооцооны хуудастай тулган шалгахад нягтлан бодогч сар бүр шатахууны тооцоог бодож баталгаажуулдаггүй тооцоо бодсон акт үйлддэггүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

5.2. Эрсдэл:

Тээвэр шатахуун зардлыг батлагдсан төсвөөс үндэслэлгүй хэтрүүлэн зарцуулах

5.3. Өгсөн зөвлөмж:

Жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог бодохдоо тухай бүр автомашины явсан замын тооцооны хуудсыг спидометрийн заалттай тулгаж, бичилт хийн тооцоог бодож нягтлан бодох бүртгэлд тусгаж байх.

5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

6. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

6.1. Илрүүлэлт:

Тухайн байгууллага нь нягтлан бодох бүртгэл бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

6.2. Эрсдэл:

Тус байгууллагын УСНББОУС-ын дагуу бүртгэл хөтлөхгүй байх

6.3. Өгсөн зөвлөмж:

Өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүйгээс санхүүгийн тайланд илэрсэн алдаа нэмэгдэж байгаа тул бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

7. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

7.1 Илрүүлэлт

Тайлант онд эхний эхэнд түлш шатахуунд 300,0 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан ба 30875,3 мянган төгрөгийн шатахуун шатах тослох материал худалдан авсан ба 27795,1 мянган төгрөг зарцуулж үлдэгдлээр 3110,2 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

7.2 Эрсдэл

Төсвийг зориулалт бусаар зарцуулах

7.3 Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж шатахууныг нөөцлөхгүй, хэмнэгдсэн зардлыг орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлж байх

7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

8. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

8.1 Илрүүлэлт

Сар бүр жолоочийн тооцооны хуудсыг хянаж баталгаажуулдаггүй, тооцоо бодсон акт үйлддэггүйгээс болж нярвын тайлан, санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайлангийн тээвэр шатахууны орлого 5221,4 мянган төгрөг, зарлага 2140,9 мянган төгрөгөөр зөрж байна.

8.2 Эрсдэл

Төсвийг зориулалт бусаар зарцуулах

8.3 Өгсөн зөвлөмж

Шатахууны тайланг анхан шатны баримтыг үндэслэн орлого авч, холбогдох эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр зарлага гарган, сар бүр харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, тухай бүр нь картыг цэнэглэж, гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг сайжруулан НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад .2020 оны 4 дүгээр сарын .20.-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	102,578,358.00	129,576,970.09
33	АВЛАГА	28,928,900.00	1,201,781.09
335	Бусад авлага	28,928,900.00	1,201,781.09
3351	Байгууллагаас авах авлага	28,928,900.00	1,201,781.09
35	БАРАА МАТЕРИАЛ	73,649,458.00	128,375,189.00
351	Түүхий эд материал	18,608,000.00	18,608,000.00
35110	Тусгай зориулалттай материал	18,608,000.00	18,608,000.00
354	Хангамжийн материал	38,831,458.00	109,767,189.00
35410	Бичиг хэргийн материал	2,915,838.00	4,484,638.00
35440	Түлш, шатах тослох материал	300,000.00	3,380,431.00
35450	Барилгын засварын материал	747,000.00	747,000.00
35460	Хүнсний материал	00.00	349,700.00
35470	Бусад хангамжийн материал	34,868,620.00	100,805,420.00
35600	Мал амьтад	16,210,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,322,658,749.35	3,150,167,274.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,322,658,749.35	3,150,167,274.81
392	Биет хөрөнгө	3,299,940,603.65	3,130,205,379.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,478,122,976.90	4,617,097,219.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,454,544,101.41	1,821,836,852.10
39204	Хуримтлагдсан элэгдэл	260,920,500.00	287,380,500.00
39205	Хуримтлагдсан элэгдэл	-92,567,139.52	-108,255,351.08
39206	Машин тоног төхөөрөмж (компьютер)	178,634,397.00	181,501,548.00
39207	Хуримтлагдсан элэгдэл	-120,219,597.69	-138,570,900.50
39213	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,662,111.00	96,377,795.00
39214	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,000,000.00	7,000,000.00
39215	Бусад үндсэн хөрөнгө	36,790,020.00	100,661,520.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-31,274,832.74	-34,218,873.84
393	Биет бус хөрөнгө	22,718,145.70	19,961,895.66
39301	Програм хангамж	14,563,000.00	13,978,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-9,844,854.30	-12,016,104.34
39303	Бусад биет бус хөрөнгө	18,000,000.00	18,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,425,237,107.35	3,279,744,244.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,336,420.00	2,177,634.13
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,336,420.00	2,177,634.13
413	Өглөг	20,336,420.00	2,177,634.13
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,088,121.13
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	20,336,420.00	1,089,513.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,404,900,687.35	3,277,566,610.78
51	Засгийн газрын хувь оролцоо	3,404,900,687.35	3,277,566,610.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	520,400,904.00	520,400,904.00
51103	- хувьцаат	520,400,904.00	520,400,904.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,433,553,596.07	2,337,982,600.59
51210	Өмнөх үеийн үр дүн	2,433,553,596.07	2,465,316,677.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-127,334,076.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	450,946,187.28	419,183,106.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,425,237,107.35	3,279,744,244.90

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	569,947,149.00	725,034,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104,679,349.00	332,129,096.00
120	Нийтлэг татварын бус орлого	104,679,349.00	332,129,096.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	104,679,349.00	332,129,096.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,675,930.00	579,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	83,003,419.00	331,549,196.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	465,267,800.00	392,905,804.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	133,856,000.00	42,899,104.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,856,000.00	42,794,104.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	331,411,800.00	350,006,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	331,411,800.00	350,006,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	819,451,493.69	806,686,178.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	818,251,493.69	806,686,178.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	788,319,515.69	800,021,840.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,493,900.00	206,041,722.00
210101	Үндсэн цалин	198,493,900.00	206,041,722.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,874,400.00	25,657,461.13
210201	Тэтгэврийн даатгал	15,913,201.00	18,512,271.73
210202	Тэтгэмжийн даатгал	1,989,149.00	1,813,246.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,681,912.00	1,450,598.68
210204	Ажилгүйдлийн даатгал	390,012.00	352,849.17
210205	Эрүүл мэндийн даатгал	3,900,126.00	3,528,494.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,027,700.00	35,871,138.00
210301	Гэрэл, цахилгаан	3,045,300.00	6,414,538.00
210302	Түлш, халаалт	25,982,400.00	29,456,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,956,584.00	28,432,770.22
210401	Бичиг хэрэг	3,016,775.00	2,494,350.00
210402	Тээвэр, шатахуун	24,223,934.00	23,353,770.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	905,700.00	2,172,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	810,175.00	412,650.00
2105	Нормативт зардал	282,450.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	282,450.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,146,866.00	3,192,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	206,000.00
210604	Урсгал засвар	12,146,866.00	2,986,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,675,000.00	18,581,150.00
210701	Гадаад албан томилолт	00.00	42,000.00
210702	Дотоод албан томилолт	5,675,000.00	9,284,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	9,254,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,609,019.00	25,229,426.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,958,019.00	23,197,426.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	1,782,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	401,253,596.69	457,015,473.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,078,600.00	12,283,000.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,900.00	450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	397,166,096.69	444,282,472.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,931,978.00	6,664,338.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,340,000.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,340,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,791,978.00	5,164,338.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,791,978.00	5,164,338.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,200,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,200,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	1,200,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-249,504,344.69	-81,651,278.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	431,450,191.13	45,682,797.86
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	885,999.23	29,472,797.86
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	16,210,000.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	430,564,191.90	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-431,450,191.13	-45,682,797.86
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-680,954,535.82	-127,334,076.58

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	486,943,730.00	393,485,704.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,675,930.00	579,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,675,930.00	579,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,675,930.00	579,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,675,930.00	579,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	465,267,800.00	392,905,804.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	133,856,000.00	42,899,104.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,856,000.00	42,794,104.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	331,411,800.00	350,006,700.00



132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	331,411,800.00	350,006,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	486,943,730.00	388,915,704.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486,943,730.00	388,915,704.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411,411,152.00	382,151,366.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,922,684.00	197,516,502.00
210101	Үндсэн цалин	161,942,484.00	197,516,502.00
210102	Нэмэгдэл	29,980,200.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,187,243.00	25,787,100.00
210201	Тэтгэврийн даатгал	15,127,200.00	17,447,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,774,000.00	2,084,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,359,289.00	1,667,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	229,901.00	417,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,696,853.00	4,169,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,122,579.00	37,501,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,045,300.00	8,045,300.00
210302	Түлш, халаалт	25,077,279.00	29,456,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,061,400.00	29,115,600.00
210401	Бичиг хэрэг	2,851,300.00	3,948,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,603,400.00	22,663,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	965,700.00	984,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,641,000.00	1,220,000.00
2105	Нормативт зардал	159,900.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	159,900.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,189,000.00	3,515,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	300,000.00
210604	Урсгал засвар	189,000.00	3,215,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,675,000.00	18,392,500.00
210702	Дотоод албан томилолт	5,675,000.00	9,326,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	9,066,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,894,346.00	49,526,764.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,243,346.00	46,556,764.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	2,970,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,199,000.00	20,796,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,099,000.00	20,696,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,532,578.00	6,764,338.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	49,940,600.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	49,940,600.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	1,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,791,978.00	5,164,338.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,791,978.00	5,164,338.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,570,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,570,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,570,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,570,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,570,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,570,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	502,400,904.00	110,689,256.00	3,409,271,416.43	4,022,361,576.43
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	502,400,904.00	110,689,256.00	613,090,160.00	4,022,361,576.43
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	-307,031,592.54
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,400,904.00	450,946,187.28	971,347,091.28	3,404,900,687.35
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,400,904.00	450,946,187.28	971,347,091.28	3,404,900,687.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	31,763,081.09
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,400,904.00	450,946,187.28	971,347,091.28	3,436,663,768.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-31,763,081.09	-31,763,081.09	-31,763,081.09
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00

Бууцаган сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	-127,334,076.57
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,400,904.00	419,183,106.19	939,584,010.19	3,277,566,610.78

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	350,606,500.00	345,527,262.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,606,500.00	345,527,262.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348,006,500.00	343,927,262.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	197,780,000.00	197,516,502.00
210101	Үндсэн цалин	197,780,000.00	197,516,502.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,674,600.00	25,674,600.00
210201	Тэтгэврийн даатгал	17,371,400.00	17,371,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,660,600.00	2,075,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,075,700.00	1,660,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	415,200.00	415,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,151,700.00	4,151,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,501,900.00	37,501,900.00
210301	Гэрэл, цахилгаан	8,045,300.00	8,045,300.00
210302	Түлш, халаалт	29,456,600.00	29,456,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,455,800.00	33,395,600.00
210401	Бичиг хэрэг	3,948,500.00	3,948,500.00
210402	Тээвэр, шатахуун	22,663,100.00	22,663,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,044,200.00	984,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,000.00	5,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,515,700.00	3,515,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	3,215,700.00	3,215,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,737,300.00	18,392,500.00
210702	Дотоод албан томилолт	9,737,300.00	9,326,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,000,000.00	9,066,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,241,200.00	7,135,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,590,200.00	4,165,160.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	00.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	2,970,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23100000.00	20796000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,000,000.00	20,696,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2600000.00	1600000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,600,000.00	1,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600,000.00	1,600,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	350,606,500.00	345,527,262.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	339,406,500.00	344,947,362.00
132001	Орон нутгийн төсвөөс	339,406,500.00	344,947,362.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,200,000.00	579,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	579,900.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	10,600,000.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	22.00
620001	Удирдах ажилтан	09.00	09.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	09.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23.00	22.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	07.00	06.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00
650010	Гэрээт ажилтан	02.00	02.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	08.00	08.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөг/
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,794,104.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,794,104.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,794,104.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,500.00
210201	Тэтгэврийн даатгал	76,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,200.00

210204	Ажилгүйдлийн даатгал	1,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,681,604.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,681,604.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,794,104.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,794,104.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,794,104.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: *Н.Бунчинсүрэн* Н.БҮНЧИНСҮРЭН 2020.02.27

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: *А.Цээням* А.ЦЭЭНЯМ 2020.02.27

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *Б.Мөнхбат* Б.МӨНХБАТ 2020.02.27

